

# Uppgifter B

## Textpaket

### Litteracitet

1

Steg 2

3

## Elever som läser och skriver





# Innehåll

|                        |          |
|------------------------|----------|
| <b>Inledning</b> ..... | <b>3</b> |
|------------------------|----------|

## **Textpaket 1**

|                         |   |
|-------------------------|---|
| Lejonet och räven.....  | 5 |
| En karta över en ö..... | 7 |
| Skorpionen .....        | 9 |

## **Textpaket 2**

|                        |    |
|------------------------|----|
| Skorpionen .....       | 12 |
| Den giriga mannen..... | 14 |
| Potatischips .....     | 16 |

## **Textpaket 3**

|                       |    |
|-----------------------|----|
| Skorpionen .....      | 19 |
| Potatischips .....    | 21 |
| Sömn.....             | 23 |
| Mjölk .....           | 25 |
| Världens städer ..... | 27 |

|                                              |           |
|----------------------------------------------|-----------|
| <b>Litteratur- och bildförteckning</b> ..... | <b>29</b> |
|----------------------------------------------|-----------|



## Inledning

Detta häfte innehåller underlag för *Uppgifter B – Textpaket*. Uppgifterna använder du tillsammans med *Samtals- och dokumentationsunderlag B* och *Bedömningsunderlag för Uppgifter B*.

Instruktionerna för hur du genomför uppgifterna finns i *Samtals- och dokumentationsunderlag B*.

Dokumentera elevens svar på uppgifterna i bedömningsunderlagen. Var uppmärksam på att svarsrutorna för ”Ja” och ”Nej” kommer i en annan ordning på elevens svarsblad när språket har läsriktningen höger–vänster.

Varje uppgift består av två blad – en text och elevens svarsblad med läsförståelsefrågor. Information om hur du väljer uppgifter till eleven finns i lärarhandledningen (se s. 6–7). Skriv ut uppgifterna i färg och enkelsidigt så att eleven kan se texten och frågorna samtidigt.

Ge gärna tolken kopior av uppgifterna du har valt, både på svenska och på elevens språk.

### Om översättningen

Översättningen använder det enligt lag (1992) nationella standard- och undervisningsspråket i Mongoliet, som är baserat på dialekten khalkha, med en för språket modifierad version av det kyrilliska alfabetet. Läs- och skrivriktningen är från vänster till höger. Mongoliska talas också i andra länder i det geografiska närområdet (Ryssland och Kina) men användare som härstammar därifrån har troligen haft ett annat undervisningsspråk än mongoliska.

### Anpassning av uppgifter för elever med funktionsnedsättning

Om du läser upp eller spelar in uppgifter för elever med svår synnedsättning behöver du anpassa uppgifter som innehåller bilder eller figurer. Kontakta en speciallärare eller specialpedagog om det behövs.

#### Textpaket 1

- Text 1. Lejonet och räven. Beskriv innehållet i bilden.
- Text 2. En karta över en ö. Uppgiften stryks.
- Text 3. Skorpionen. Beskriv skorpionen i bilden. (Ingår även i textpaket 2 och 3)

#### Textpaket 2

- Text 3. Potatischips. Använd riktiga potatischips. (Ingår även i textpaket 3)

#### Textpaket 3

- Text 3. Sömn. Figuren kan strykas. Frågorna 3 och 4 som bygger på information i figuren stryks.
- Text 5. Världens städer. Diagrammet kan strykas. Frågorna 2 och 4 som bygger på information i diagrammet stryks.

Läs mer i *Anpassning för elever med funktionsnedsättning*.

# Textpaket 1



## Арслан ба үнэг

Арслан агуй дотроо хэвтэж байв.

Тэр тэнд өдөр шөнөгүй хэвтэж байв.

Түүнээс зөвхөн бага зэрэг ядарсан архирах чимээ л сонсогдоно.

– Тэр өвдчихөж гэж бусад амьтад бодон арсланг өрөвдөнө.

Тэд жижиг бэлэг барин арслангийн агуй руу орж эхэлжээ.

Гэвч үнэг тийшээ ороогүй аж.

Арслан зөөлөн хоолойгоор ийнхүү асуужээ:

– Найзаа чи яагаад ирэхгүй байгаа юм бэ? Бусад амьтад бүгдээрээ энд байсан шүү дээ.

– Би оръё гэж гэж бодсон л доо, гэвч би хөлийн мөрнүүдийг хараад айсан, гэж үнэг хэлжээ. Бүх мөрнүүд чиний агуй руу орсон мөртлөө агуйгаас гарсан нэг ч мөр алга. Тиймд гадаа үлдсэн нь дээр байх.



## “Арслан ба үнэг”- ийн асуултууд


Текстийн талаарх дараах асуултуудад Тийм эсвэл Үгүй гэж хариулна.

|                                             | Тийм                     | Үгүй                     |
|---------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Арслан агуйдаа байнга байсан уу?         | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Үнэг арслан руу орсон уу?                | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Үнэг арсланд бэлэг өгсөн үү?             | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Арслан бусад амьтдыг идчихсэн байсан уу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Дараах асуултуудад чи амаар хариулт өгнө.

5. Энэ текст юуг өгүүлж байгааг чи өөрийн үгээр товч ярьж чадах уу?
6. Арслан өвдсөн байсан гэж чи бодож байна уу? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?
7. Үнэг бусад амьтдаас илүү ухаантай байсан уу? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?
8. Энэ түүхээс суралцах юм байна гэж чи бодож байна уу? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

## Арлын газрын зураг



## “Арлын газрын зураг” – ийн асуултууд

**Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.**

**1. Энэ газруудын аль нь боомттой хамгийн ойр вэ?**

- A ☐ Хот  
Б ☐ Нуур  
В ☐ Фермийн аж ахуй

**2. Энэ газруудын аль нь хотын хойд зүгт байна вэ?**

- A ☐ Нисэх онгоцны буудал  
Б ☐ Ой  
В ☐ Фермийн аж ахуй

**3. Чи хотоос нуур руу явбал аль зүг рүү явах вэ?**

- A ☐ Хойд  
Б ☐ Баруун  
В ☐ Зүүн

**4. Чи өөрийгөө арал дээр алхаж явна гэж бод. Дараах зааврыг дагана уу.**

1. Тосгоноос эхлэ.
2. Боомт хүрэх замыг дага.
3. Хоёр дахь замын уулзвар дээр зүүн тийш эргэ.
4. Зам дуустал яв.
5. Чи одоо хаана байна?

- A ☐ Фермийн аж ахуй  
Б ☐ Хот  
В ☐ Боомт

## Хилэнц – хатгуурт аалзан хорхой

Халуун дулаан газраар явахдаа ханан дахь жижиг нүхэнд эсвэл чулуун дотор хуруугаа хийх огт сайн юм биш. Гутлаа өмсөөгүй удсан бол углахаасаа өмнө сэгсрэх хэрэгтэй. Гуталд ямар нэгэн зүйл орсон байж болно шүү дээ. Яагаад гэвэл хилэнц гэрэлд дургүй учир өдөржин нүх, харанхуй хөндий рүү шигдэж хэвтдэг. Хилэнц дэлхийн бүх өнцөгт дулаан орнуудад амьдардаг ч хүнд үзэгдэх нь ховор.

### Олзоо хатгаж алдаг

Хилэнц үнэхээр хортой байж болох ч, дийлэнх төрөл нь хүний амь насанд аюултай биш. Хилэнц аль төрөл гэдгээсээ хамаарч нэгээс хорин сантиметрийн урттай болдог ч бүгд бөгснийхөө үзүүрт хорт хатгууртай. Хилэнц олзоо алахдаа бөгсөө нуруун дээгүүрээ хотойлгож сарвуундаа барьсан олзыг хатгадаг. Айсан хилэнц хурдан эргэлдэж байнга хатгуураа дайсан руугаа чиглүүлдэг.

Хилэнц шөнийн цагаар том аалз болон бусад жижиг шавьж агнадаг. Тэд сарвуугаараа тэмтэрч урагшлан, олзоос зуурч хорт хатгуураараа алдаг.



Хилэнц

**“Хилэнц – хатгуурт аалзан хорхой” – ны асуултууд**

**Дараах текстийн талаарх асуултад Тийм эсвэл Үгүй гэж хариулна.**

|                                          | Тийм                     | Үгүй                     |
|------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Хилэнц харанхуйд дуртай юу?           | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Бүх хилэнц хүн алж чадах уу?          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Бүх төрлийн хилэнц ижил хэмжээтэй юу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Хилэнц олзоо сарвуугаараа барьдаг уу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

5. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?
6. Хилэнцийн тухай текстэд гутлаа сэгсрэх хэрэгтэй гэж байна. Яагаад тэгэх хэрэгтэй гэж чи бодож байна? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

# Textpaket 2



## Хилэнц – хатгуурт аалзан хорхой

Халуун дулаан газраар явахдаа ханан дахь жижиг нүхэнд эсвэл чулуун дотор хуруугаа хийх огт сайн юм биш. Гутлаа өмсөөгүй удсан бол углахаасаа өмнө сэгсрэх хэрэгтэй. Гуталд ямар нэгэн зүйл орсон байж болно шүү дээ. Яагаад гэвэл хилэнц гэрэлд дургүй учир өдөржин нүх, харанхуй хөндий рүү шигдэж хэвтдэг. Хилэнц дэлхийн бүх өнцөгт дулаан орнуудад амьдардаг ч хүнд үзэгдэх нь ховор.

### Олзоо хатгаж алдаг

Хилэнц үнэхээр хортой байж болох ч, дийлэнх төрөл нь хүний амь насанд аюултай биш. Хилэнц аль төрөл гэдгээсээ хамаарч нэгээс хорин сантиметрийн урттай болдог ч бүгд бөгснийхөө үзүүрт хорт хатгууртай. Хилэнц олзоо алахдаа бөгсөө нуруун дээгүүрээ хотойлгож сарвуундаа барьсан олзыг хатгадаг. Айсан хилэнц хурдан эргэлдэж байнга хатгуураа дайсан руугаа чиглүүлдэг.

Хилэнц шөнийн цагаар том аалз болон бусад жижиг шавьж агнадаг. Тэд сарвуугаараа тэмтэрч урагшлан, олзоос зуурч хорт хатгуураараа алдаг.



Хилэнц

**“Хилэнц – хатгуурт аалзан хорхой” – ны асуултууд**

**Дараах текстийн талаарх асуултад Тийм эсвэл Үгүй гэж хариулна.**

|                                          | Тийм                     | Үгүй                     |
|------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Хилэнц харанхуйд дуртай юу?           | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Бүх хилэнц хүн алж чадах уу?          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Бүх төрлийн хилэнц ижил хэмжээтэй юу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Хилэнц олзоо сарвугаараа барьдаг уу?  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

5. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?
6. Хилэнцийн тухай текстэд гутлаа сэгсрэх хэрэгтэй гэж байна. Яагаад тэгэх хэрэгтэй гэж чи бодож байна? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

## Шуналтай эр

Нэгэн шуналтай эр өөрийн эзэмшлийн бүх зүйлийг зарж, алтан зооснуудаа хайлуулаад нэгэн том цул болгожээ. Тэр алтан цулаа цэцэрлэгтээ нэгэн модны дор булав. Тэр өдөр бүр модон дээр очдог байв. Нэгэн өдөр түүний хөршүүдийн нэг нь түүнийг хараад, түүнийг юу хийж байгааг нь шууд ойлгожээ. Тэр шуналтай эрийг явсныг далимдуулаад алтан цулыг ухаж гаргаад, аваад явчихжээ.

Шуналтай эр маргааш нь ирээд эрдэнэсээ харах гэтэл оронд нь нүх олжээ. Тэр бачимдсандаа уйлж, үсээ зулгааж эхэлжээ. Хажуугаар нь санамсаргүй алхаж явсан нэгэн найз нь юу болсныг асуутал шуналтай эр юу болсныг ярив.

– Өө, ийм л юм болсон юм уу, тэгвэл чамд гутрах зүйл ерөөсөө байхгүй, гэж найз нь хэлжээ. Яагаад гэвэл тэр алт үнэндээ хэзээ ч чинийх байгаагүй. Чи тэгснээс нэг чулуу авч нүхэнд хийгээд, тэрийгээ алтан цул гээд өөртөө итгүүл! Чамд түүнээс эдлэх баяр жаргал, ашиг тус яг адилхан.

## “Шуналтай эр” – ийн асуултууд

**Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.**

### 1. Шуналтай эр яаж алтан цултай болсон бэ?

- A ☐ Хөршөөсөө худалдаж авсан.
- Б ☐ Мөнгөөр хийсэн.
- В ☐ Цэцэрлэгээсээ олсон.

### 2. Шуналтай эр яагаад өдөр бүр мод руу очдог байсан бэ?

- A ☐ Нэмж алт булах гэж.
- Б ☐ Алтаа ухаж гаргах гэж.
- В ☐ Алтаа манах гэж.

### 3. Энэ түүхээс хүн юу сурахаар байна?

- A ☐ Хүн өөрийн баялгаас бусадтай хуваалцах ёстой.
- Б ☐ Хүн зөвхөн ашиглагдаж буй баялгаас баяр жаргал эдлэнэ.
- В ☐ Хүн дандаа өөрийн хөрш, найзуудыг сонсох ёстой.

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

- 4. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?
- 5. Шуналтай эр яагаад өөрийн эзэмшлийн бүх зүйлийг зарсан гэж чи бодож байна? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?
- 6. Яагаад найз нь түүнийг нэг чулуу нүхэнд хийгээд булах нь яг адилхан гэж хэлсэн бэ? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

## Төмсний чипс

Чипс нь төмсний шарсан нимгэн хэрчмүүд бөгөөд 19-р зууны хамгийн их яригдсан нээлтийн нэг юм. Чипсийг хэн анх нээж, зарж эхэлсэн талаар олон түүх байдаг, гэтэл энэ түүхүүдийн аль нь үнэний хувьтай гэдгийг хэлэхэд хэцүү.



Төмсний чипс

Хамгийн их тархсан түүх нь тогооч Жорж Крамын тухай юм. 1853 оны 8 сарын 24-нд Крам нэгэн үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулахыг оролджээ. Тэр төмсийг нарийхан хэрчиж шараад, давслаад өгтөл, дүнд нь үйлчлүүлэгч гомдолтойгоос маш сэтгэл хангалуун болжээ. Энэ түүх үнэн байж болох ч, өөр тогооч нар төстэй санааг тус зуунд бас гаргасан нь тодорхой байна. Зөвхөн Америкт төстэй зүйлүүд хоёр хоолны номонд дурьдагдсан байдаг ба өөр хувилбарууд Их Британид гарч иржээ.

Зөвхөн 1890 оноос эхлэн чипсийг хүнсний дэлгүүрээр зарж эхэлсэн ба гагцхүү чипсийн үйлдвэрлэлийг хөнгөвчилсөн төмс шарагч 1920 оны сүүлээр зохион бүтээгдсэнээс л хойш чипсийн үйлдвэрлэл худалдаа бодитоор өссөн юм. Үүний дараах арван жилд савлалт өөрчлөгдсөнөөс хойш Америкийн нийт нутагт хол зайнд тараагдаж эхэлсэн байна. Европын хувьд дэлгүүрүүд дэх чипсийн тархалт 1950-аад он хүртэл хойшлогджээ.

## “Төмсний чипс” – ийн асуултууд

**Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.**

**1. Зохиогч яагаад энэ текстийг бичсэн бэ?**

- A ☐ Уншигчид чипсийн түүхийн тухай мэдээлэл өгөхийн тулд.  
Б ☐ Уншигчийг хөгжилтэй түүхээр зугаацуулахын тулд.  
В ☐ Уншигчид чипс хийх заавар өгөхийн тулд.

**2. Бид чипсийг хэн нээснийг мэдэх үү?**

- A ☐ Тийм, Жорж Крам нээсэн.  
Б ☐ Үгүй, хэд хэдэн өөр хүн байх магадлалтай.  
В ☐ Үгүй, гэхдээ хаана нээгдсэнийг мэднэ.

**Дараах мэдэгдлийн аль нь текстэд чипсийн тухай бичсэн зүйлтэй таарч байна?**

**Мэдэгдэл бүрийн ард байгаа Тийм эсвэл Үгүй гэсэн хариултад аль нэгийг чагтлана.**

- |                                                                           | Тийм                     | Үгүй                     |
|---------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 3. Хүн чипс идэж эхлээд хэр удаж байгааг бид барагцаалбал мэднэ.          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Чипс анх зарж эхэлсэн тив бол Европ.                                   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. 20-р зуунд чипсийг илүү идэж эхэлсэн байдалд нэгээс илүү шалтгаан бий. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

6. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах үү?

# Textpaket 3



## Хилэнц – хатгуурт аалзан хорхой

Халуун дулаан газраар явахдаа ханан дахь жижиг нүхэнд эсвэл чулуун дотор хуруугаа хийх огт сайн юм биш. Гутлаа өмсөөгүй удсан бол углахаасаа өмнө сэгсрэх хэрэгтэй. Гуталд ямар нэгэн зүйл орсон байж болно шүү дээ. Яагаад гэвэл хилэнц гэрэлд дургүй учир өдөржин нүх, харанхуй хөндий рүү шигдэж хэвтдэг. Хилэнц дэлхийн бүх өнцөгт дулаан орнуудад амьдардаг ч хүнд үзэгдэх нь ховор.

### Олзоо хатгаж алдаг

Хилэнц үнэхээр хортой байж болох ч, дийлэнх төрөл нь хүний амь насанд аюултай биш. Хилэнц аль төрөл гэдгээсээ хамаарч нэгээс хорин сантиметрийн урттай болдог ч бүгд бөгснийхөө үзүүрт хорт хатгууртай. Хилэнц олзоо алахдаа бөгсөө нуруун дээгүүрээ хотойлгож сарвуундаа барьсан олзыг хатгадаг. Айсан хилэнц хурдан эргэлдэж байнга хатгуураа дайсан руугаа чиглүүлдэг.

Хилэнц шөнийн цагаар том аалз болон бусад жижиг шавьж агнадаг. Тэд сарвуугаараа тэмтэрч урагшлан, олзоос зуурч хорт хатгуураараа алдаг.



Хилэнц

**“Хилэнц – хатгуурт аалзан хорхой” – ны асуултууд**

**Дараах текстийн талаарх асуултад Тийм эсвэл Үгүй гэж хариулна.**

|                                          | Тийм                     | Үгүй                     |
|------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Хилэнц харанхуйд дуртай юу?           | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Бүх хилэнц хүн алж чадах уу?          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Бүх төрлийн хилэнц ижил хэмжээтэй юу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Хилэнц олзоо сарвугаараа барьдаг уу?  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

5. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?
6. Хилэнцийн тухай текстэд гутлаа сэгсрэх хэрэгтэй гэж байна. Яагаад тэгэх хэрэгтэй гэж чи бодож байна? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

## Төмсний чипс

Чипс нь төмсний шарсан нимгэн хэрчмүүд бөгөөд 19-р зууны хамгийн их яригдсан нээлтийн нэг юм. Чипсийг хэн анх нээж, зарж эхэлсэн талаар олон түүх байдаг, гэтэл энэ түүхүүдийн аль нь үнэний хувьтай гэдгийг хэлэхэд хэцүү.



Төмсний чипс

Хамгийн их тархсан түүх нь тогооч Жорж Крамын тухай юм. 1853 оны 8 сарын 24-нд Крам нэгэн үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулахыг оролджээ. Тэр төмсийг нарийхан хэрчиж шараад, давслагд өгтөл, дүнд нь үйлчлүүлэгч гомдолтойгоос маш сэтгэл хангалуун болжээ. Энэ түүх үнэн байж болох ч, өөр тогооч нар төстэй санааг тус зуунд бас гаргасан нь тодорхой байна. Зөвхөн Америкт төстэй зүйлүүд хоёр хоолны номонд дурьдагдсан байдаг ба өөр хувилбарууд Их Британид гарч иржээ.

Зөвхөн 1890 оноос эхлэн чипсийг хүнсний дэлгүүрээр зарж эхэлсэн ба гагцхүү чипсийн үйлдвэрлэлийг хөнгөвчилсөн төмс шарагч 1920 оны сүүлээр зохион бүтээгдсэнээс л хойш чипсийн үйлдвэрлэл худалдаа бодитоор өссөн юм. Үүний дараах арван жилд савлалт өөрчлөгдсөнөөс хойш Америкийн нийт нутагт хол зайнд тараагдаж эхэлсэн байна. Европын хувьд дэлгүүрүүд дэх чипсийн тархалт 1950-аад он хүртэл хойшлогджээ.

## “Төмсний чипс” – ийн асуултууд

**Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.**

**1. Зохиогч яагаад энэ текстийг бичсэн бэ?**

- A ☐ Уншигчид чипсийн түүхийн тухай мэдээлэл өгөхийн тулд.  
Б ☐ Уншигчийг хөгжилтэй түүхээр зугаацуулахын тулд.  
В ☐ Уншигчид чипс хийх заавар өгөхийн тулд.

**2. Бид чипсийг хэн нээснийг мэдэх үү?**

- A ☐ Тийм, Жорж Крам нээсэн.  
Б ☐ Үгүй, хэд хэдэн өөр хүн байх магадлалтай.  
В ☐ Үгүй, гэхдээ хаана нээгдсэнийг мэднэ.

**Дараах мэдэгдлийн аль нь текстэд чипсийн тухай бичсэн зүйлтэй таарч байна?**

**Мэдэгдэл бүрийн ард байгаа Тийм эсвэл Үгүй гэсэн хариултад аль нэгийг чагтлана.**

- |                                                                           | Тийм                     | Үгүй                     |
|---------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 3. Хүн чипс идэж эхлээд хэр удаж байгааг бид барагцаалбал мэднэ.          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Чипс анх зарж эхэлсэн тив бол Европ.                                   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. 20-р зуунд чипсийг илүү идэж эхэлсэн байдалд нэгээс илүү шалтгаан бий. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Дараах асуултад амаар хариулт өгнө.**

6. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах үү?

# Нойр

**Бүх амьтад унтах хэрэгтэй, хүн ч тэр амьтан ч тэр. Гэхдээ яагаад? Судлаачид хүртэл үүний хариултыг мэдэхгүй. Эсвэл биднийг унтаж байхад юу болдогийг бас мэдэхгүй. Гэхдээ бид унтах хэрэгтэй гэдэг дээр ямар ч эргэлзээ байхгүй.**

**Нойргүйгээр бид үхнэ.** Нойр бол нэг төрлийн амралт юм. Эргэн тойронд чинь юу болж байгааг чи мэдэхгүй ч гэсэн. Нэг утгаараа чи унтаж байхдаа ухаан алдсан байна гэж хэлж болох юм. Гэхдээ чи сэрэхээргүй тийм гүн байдлаар ухаан алдана гэсэн үг биш юм.

## Нойрны мөчлөг

Нойр нь тус бүр 90 минут орчим үргэлжлэх давтагдсан мөчлөгөөр болдог. Нойрны мөчлөг бүр таван үе шаттай, нойрны мөчлөгийн диаграммыг харна уу.

## Зүүдэн нойр ба гүн нойр

Тав дах үе шатыг зүүдэн нойр гэнэ. Энэ үед нүд түргэн хөдөлж, бид энэ үед зүүдэлдэг. Зүүдэн нойр өнгөцхөн байдаг, өөрөөр хэлбэл тэр үед бид гүн унтдаггүй. Зүүдэн нойр 90 минут болгонд давтагдаж, бидний нойрны үеийн дөрөвний нэгтэй тэнцэх хугацаанд үргэлжилдэг. Нэг өөр үе шат нь гүн нойр юм. Энэ үед бидний бие нөхөн сэргэж, бид шинэ зүйл сурахдаа сайн болдог. Гүн нойрны үед олсон мэдлэг бэхжиж бидний ой тогтоомжид амархан хадгалагдана.



## Нөхөн унтах

Хэрвээ чи нэг өдөр маш оройтож орондоо орсон бол маргааш нь хоёр дахин илүү их унтах ёстой гэж бодох нь амархан. Гэтэл энэ бол худлаа. Хүний бие алдсан нойроо нөхөхдөө маш чадварлаг. Чи бага унтсан үед гүн унтсанаар нойроо нөхөж чадна.

## “Нойр” – ын асуултууд

Дараах мэдэгдлийн аль нь текстэд нойрны талаар бичсэн зүйлтэй таарч байна? Мэдэгдэл бүрийн ард байгаа Тийм эсвэл Үгүй гэсэн хариултын аль нэгийг нь чагтлана.

- |                                                                                                        | Тийм                     | Үгүй                     |
|--------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Хүнд яагаад нойр хэрэгтэйг судлаачид мэднэ.                                                         | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Зүүдэн нойрны үед хүн өнгөцхөн ундтаг.                                                              | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Шөнийн дийлэнх үер бид зүүдэлдэг.                                                                   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Хүнийг сэрээхэд зүүдэн нойрноос нь өмнө сэрээх нь зүүдэн нойрных нь дараа сэрээхээс амархан байдаг. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Дараах өгүүлбэрийн үргэлжлэлийг зөв хариултаас олж чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.

5. Нэг эсвэл хоёр шөнө бага унтсан бол ...
- А ☐ нойроо нөхөхийн тулд дараа шөнө нь хоёр дахин илүү унтах хэрэгтэй.
- Б ☐ хүний бие дараа шөнө нь гүн унтсанаар алдсан нойрыг нөхөж чадна.
- В ☐ дараа өдөр нь ердийнхөөс эрт орондоо орж алдсан нойроо нөхөж чадна.

Дараах асуултад аман хариулт өгнө.

6. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?

# Сүү

## Сонинд илгээсэн захидал

Шведэд бүх сурагчдад сургуульд өдрийн хоол өгдөг ба хоолон дээр нь ихэвчлэн сүү өгдөг. Сүүлийн үед харин сүү уух нь үнэхээр сайн уу үгүй юу гэдгийг их хэлэлцэх болсон. Доор хоёр өөр хүн сургуульд хүүхдүүдэд сүү өгч байгаа талаар юу гэж бодож байгаа талаар чи унших болно.

### 1.

#### Сургуулийн хүүхдүүдэд сүүний оронд ус өг

Үнээний сүү сургуульд өгөх нь байгалийн жамд нийцэхгүй. Хүн бол өөр амьтны төрлийн сүү хэрэглэдэг дэлхий дээрх цорын ганц амьтны төрөл юм.

Бидний өнгөрсөн Лхагва гаригт сонинд уншсан Уппсала Их сургуулийн томоохон судалгаа бидний үхрийн сүүний талаарх хуучны шүүмжлэлгүй ойлголтыг орвонгоор нь эргүүлээ. Судлаачид сүүний өндөр хэрэглээ богино наслалт болон ихэссэн ясны хугаралтай холбоотой гэж тогтоожээ.

Үхрийн сүү нь хүн ардын эрүүл мэнд, байгаль орчинд муу төдийгүй байгалийн жамд нийцэхгүй. Тиймд бид Шведийн сургуулиудад үхрийн сүү өгөхийг болиулж оронд нь хүүхдүүдэд байгаль орчинд халгүй шинэ ундаа, өөрөөр хэлбэл, усаар цангаагаа гаргахыг заах цаг болсон.

#### Андерс Свенссон

“Ногоогоор хооллоё” нийгэмлэгийн төлөөлөгч

### 2.

#### Сургуулийн хоолонд сүү хэрэгтэй

Андерс Свенссонд өгөх хариу

Андерс Свенссон хүүхдүүдэд сургуульд нь сүү өгүүлэхийг хүсэхгүй байна. Бид болон Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) харин эсрэг үзэл бодолтой байна - хүүхэд бүр сургуульдаа үнэгүй сүү уух эрхтэй.

Бидэнд өдөр бүр хэрэгтэй 22 тэжээлийн бодисын 18 нь сүүнд байдаг тул сургуулийн хүүхдийн өдөр тутмын тэжээлийн хэрэгцээг хангахад сүү томоохон үүрэг гүйцэтгэдэг. Хоол хүнсний дутагдалтай улс оронд сургуулийн сүү нь олон хүүхдийн хувьд амин чухал тэжээлийн эх үүсвэр болж байна. Үүнээс гадна, сургуулийн өдрийн хоол нь сүү нэмж өгөхгүй бол хангалттай тэжээл өгч чадахгүй байна гэдгийг харуулсан сүүлийн үеийн судалгаа байна.

Кристианстадын Дээд сургуулийн хоол тэжээлийн судлаач Улла Русандэр, Шведийн нэгэн хотын гурван өөр сургуулийн 10 насны сурагчдын нэг долоо хоногийн хугацаанд идсэн сургуулийн хоолны тэжээлийн агууламжийг судалжээ. Сургуулиудын өдрийн хоолны цэс яг адилхан байв. Судалгааны үр дүнгээр, хүүхдүүдийн хувьд хоолон дээрээ сүү уух нь чухал ба ялангуяа бага хэмжээгээр иддэг эсвэл өдрийн хоолны завсарлагаар хангалттай хоол идэж амждаггүй хүүхдүүдийн хувьд улам илүү чухал гэж харуулжээ. Хүүхдүүдийн хувьд жишээ нь кальци, витамин B12, магниг хангалттай хэмжээгээр авахын тулд сүү хэрэгтэй байсан байна. Тийм учраас сүү бол сургуульд заавал байх ёстой зүйл юм.

#### Петра Страндберг

Шведийн Сүүн аж ахуйчдын төлөөлөгч

## “Сүүний талаар сонинд илгээсэн захидал” – ын асуултууд

Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.

### 1. Страндберг яагаад сургуулийн хүүхдэд сүү чухал гэж үзэж байгаа вэ?

- A ☐ Сүү ууснаар хүүхдүүд сургууль дээрээ хоол илүү их иддэг.  
 Б ☐ Сүүний ачаар хүн удаан насалдаг.  
 В ☐ Сүүнд олон тэжээлийн бодис агуулагддаг.

### 2. Свенссон яагаад сургуулийн хүүхдүүд сүүний оронд ус уух ёстой гэж үзэж байгаа вэ?

- A ☐ Ус сүүнээс хямд.  
 Б ☐ Ус байгаль орчинд илүү эвээлтэй.  
 В ☐ Ус амны цангааг илүү сайн гаргана.

### 3. Текстүүдээс харахад, судалгаа юуг харуулсан бэ?

- A ☐ Сүү уух нь сайн, муу аль аль үр дагавартай гэдгийг.  
 Б ☐ Сургуулийн хоол сүүгүйгээр хангалттай шим тэжээлтэй гэдгийг.  
 В ☐ Сүүний өндөр хэрэглээ яс бэхжүүлдэг гэдгийг.

### 4. Страндберг яагаад сонинд бичих болсон бэ?

- A ☐ Тэр Свенссоныг яагаад буруу бодож байна гэдгийг тайлбарлахыг хүсч байна.  
 Б ☐ Тэр ус яагаад байгаль орчинд ээлтэй вэ гэдгийг тайлбарлахыг хүсч байна.  
 В ☐ Тэр хүүхдүүдийг сургууль дээрээ хоол бага идэхийг хүсэхгүй байна.

Дараах мэдэгдлийн аль нь сүүний талаар текстэд бичсэн зүйлтэй таарч байна?

Мэдэгдэл бүрийн ард байгаа Тийм эсвэл Үгүй гэсэн хариултын аль нэгийг чагтлана.

- |                                                                                                     | Тийм                     | Үгүй                     |
|-----------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 5. Свенссон хүн сүү хэтрүүлж уувал богино насалдаг гэж үзэж байна.                                  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6. Свенссон Страндберг хоёр тус тусын сонинд илгээсэн захидалдаа адилхан судлаачдыг дурьдсан байна. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7. Судлаачид сүүний үйлчлэлийн талаар санал нэгтэй байна.                                           | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Дараах асуултад аман хариулт өгнө.

8. Чи текст юу хэлж байгааг өөрийн үгээр товч ярьж чадах уу?  
 9. Текстүүдийн аль нь чамд илүү үнэмшилтэй санагдсан бэ? Чи яагаад ингэж бодож байгаагаа ярьж чадах уу?

## Дэлхийн хотууд улам хурдан өргөжин тэлж байна

Дэлхий дахь хот руу шилжих явц улам өндөр хурдацтайгаар үргэлжилж байна. 2050 он гэхэд хотын хүн ам 2,4 тэрбумаар өснө гэсэн НҮБ-ийн урьдчилсан таамаг байна. Тэгээд эдгээр хүмүүсийг бүгдийг нь багтаахын тулд хотууд Энэтхэгийн талбайтай ижил гадаргуу дээр өргөжин тэлэх магадлалтай.

20-р зуунд дэлхийн хэмжээнд хотод амьдарч байсан хүн амын тоо 220 саяас 2,8 тэрбум хүртэл өссөн байна. Мөн НҮБ-ийн мэдээгээр 2008 онд хот ба хүн амын төвлөрөл ихтэй газар амьдарч байгаа хүний тоо хөдөө орон нутгийнхаас анхны удаа давжээ.

2013 онд дэлхийн хотын хүн ам 3,6 тэрбум орчим гэж тооцоологдсон, гэтэл 2030 онд 5 орчим тэрбум, 2050 онд 6 тэрбумыг давна гэсэн НҮБ-ийн урьдчилсан таамаг байна. Европ ба Хойд болон Өмнөд Америкийн хүн амын дийлэнх нь аль хэдийнээ хот болон нягтшил ихтэй газар амьдарч байна, харин Африк, Азийн хотын хүн ам эрс өсөх босгон дээр иржээ.


### Хотуудын өргөжин тэлэлт асуудал мөн ч бас боломж юм

Хотууд өргөжин тэлэх нь олон талын хүнд асуудал үүсгэж байгаа юм, яагаад гэвэл өндөр хурдацтай хотшил нь эрүүл мэнд, байгаль орчны асуудалд хүргэж байгаа юм. Үүний жишээ бол агаарын бохирдол мөн шаардлагад нийцэхгүй эрүүл ахуйн нөхцөл билээ. Гэтэл үүний зэрэгцээгээр өргөжин тэлж буй том хотууд нь хөдөө орон нутагт олдохгүй тийм боломжийг олон хүнд олгож байна, үүний жишээ бол ажлын байр, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ болон сурч боловсрох боломж илүү сайн байдаг явдал юм.

Хүн амын өндөр нягтшилтай газар амьдардаг хүмүүсийн тоо нэмэгдсэнээр эрчим хүч, тээврийн хэрэгцээг багасгаж, ингэснээр цаг агаарын ачааллыг багасгах боломжтой.

### Дэлхийн хүн амын өсөлт 1961-2012 ба прогноз 2013-2050

Тэрбум



## “Дэлхийн хотууд улам хурдан өргөжин тэлж байна” – ы асуултууд

Чи өөрийн зөв гэж бодож байгаа хариултыг чагтлана. Зөвхөн нэг хариултыг чагтлана.

1. Текстэд бичсэнээр, хүмүүс хот руу шилжиж байгаагийн хамгийн том сөрөг үр дагавар юу вэ?  
А ☐ Хотуудын орчин муудна.  
Б ☐ Хотууд өргөжин тэлнэ.  
В ☐ Тээвэрлэлтийн хэрэгцээ өснө.
2. 2040 онд хотуудад барагцаалбал хичнээн хүн амьдарна гэсэн тооцоо байгаа вэ?  
А ☐ 6,4 орчим тэрбум  
Б ☐ 3,6 орчим тэрбум  
В ☐ 5,7 орчим тэрбум
3. Текстэд бичсэнээр, хотын хүн амын өсөлтийн хамгийн том шалтгаан юу вэ?  
А ☐ Хотууд байгаль орчинд ээлтэй.  
Б ☐ Хотуудын амьдралын нөхцөл байдал илүү сайн.  
В ☐ Хотуудад нэг газраас нөгөө рүү очиход илүү амар.
4. Дэлхийн хүн ам 1961 онд хот, хөдөө орон нутаг хоёрын хооронд яаж хуваарилагдаж байсан бэ?  
А ☐ Хөдөө орон нутагт амьдардаг хүмүүсийн тоо хотод амьдардаг хүмүүсийнхээс хоёр дахин илүү байсан.  
Б ☐ Хотод амьдардаг хүмүүсийн тоо хөдөө орон нутагт амьдардагийнхаас илүү байсан.  
В ☐ Хотод амьдардаг хүмүүсийн тоо хөдөө орон нутагт амьдардагийнхтай адилхан байсан.

Дараах асуултанд чи амаар хариулна.

5. Текст юу хэлж байгааг чи өөрийн үгээр товч ярьж чадах уу?
6. Текстэд бичсэнээр, хотод амьдардаг хүний тоо улам нэмэгдэнэ гэсэн байна. Хөдөө орон нутагт амьдрах нь ямар давуу талтай гэж чи бодож байна?

## Litteraturförteckning

Aisopos. Den girige. I: *Aisopos' fabler*. Ny översättning av Erik Hedén med illustrationer av Arthur Rackham. 1919. Stockholm: Svenska andelsförlaget. (bearbetad)

Aronsson, Karin & Stellan Ottosson, 1993. Lejonet och räven. I: K. Aronsson & S. Ottosson; illustrationer I-K Eriksson & M. Korotyńska, *Min läsebok Blå rosen*. 2:a uppl. Stockholm: Liber. (bearbetad)

Borgström, Håkan, 2010. Sover kroppen när du sover? I: H. Borgström. 2010. *Kroppens mysterier*. Enskede: Borgströms Förlag. (bearbetad)

Carlberg, Jonas, 2014. Mjölken behövs till skolmaten. *Upsala Nya tidning*. Insändare. Publicerad 2014-11-11. (bearbetad)

*En karta över en ö*. Kartan och frågorna anpassade från IEA Reading Literacy Study. © 1990. International Association for the Evaluation of Educational Achievement (IEA). The Hague: International Association for the Evaluation of Educational Achievement (IEA), IEA Secretariat<sup>1</sup>.

Harrison, Dick, 2014. Hur länge har vi ätit potatischips? Historiebloggen. *Svenska Dagbladet* <http://blog.svd.se/historia/2014/09/28/hur-lange-har-vi-ait-potatischips/?fromMobile=true> Publicerad 2014-09-28. Hämtad 2014-10-19. (bearbetad)

Moström, Jerker, 2013. Världens städer växer allt snabbare. SCB. Statistiska centralbyrån. <http://www.scb.se/sv/Hitta-statistik/Artiklar/Varldens-stader-vaxer-allt-snabbare/#> Publicerad 2013-10-10. Hämtad 2015-01-08. (utdrag)

Paulsson, Jonas, 2014. Ge barnen havremjolk i stället. *Upsala Nya Tidning*. Insändare. Publicerad 2014-11-04. (bearbetad)

Åström, Karin, 2001. Skorpionen – ett spindeldjur med gadd. I: S. Andersson, K. Åström & S. Rune. *Boken om världen*. Stockholm: Liber. (Utdrag)

## Bildförteckning

Lejonet och räven. Eriksson, Inga-Karin, 1993. I: K. Aronsson & S. Ottosson; illustrationer I-K Eriksson & M. Korotyńska, *Min läsebok Blå rosen*. 2. uppl. Stockholm: Liber.

Fotografi på skorpion. Hämtad 2015-06-24  
[https://upload.wikimedia.org/wikipedia/commons/6/6d/Emperor\\_scorpion\\_or\\_Imperial\\_scorpion\\_\(Pandinus\\_imperator\).jpg](https://upload.wikimedia.org/wikipedia/commons/6/6d/Emperor_scorpion_or_Imperial_scorpion_(Pandinus_imperator).jpg)

Fotografi på potatischips. Hämtad 2015-02-03  
[https://pixabay.com/p-476359/?no\\_redirect](https://pixabay.com/p-476359/?no_redirect)

<sup>1</sup> Att IEAs skrifter, studiematerial och undersökningar med organisationens tillstånd får användas för forsknings- och utbildningsändamål ska inte tolkas som att IEA medverkat i eller godkänt någon del av forskningen, eller rapporteringen kring den, eller de utbildningsprogram vari materialet används.